

## **С.БОЛД: Төгрөгийн хадгаламжаа доллар болгож байгаа хүмүүс эрсдэлд орж болзошгүй**

**Монгол банкны валют эдийн засгийн газрын Төлбөр тэнцлийн статистик судалгааны хэлтсийн дарга С.Болдтой ярилцлаа.**

**-Хөгжлийн банкны ажил удааширнаас маш олон том төслүүд хүлээгдчихлээ гэж байгаа. Үнэхээр тус банкны үйл ажиллагаа зогсонги байгаа юм уу?**

-Хөгжлийн банк бонд гаргалаа, гаргасан бондынхоо эх үүсвэрийг дотоодын эдийн засагт татаж оруулж ирлээ. Гэхдээ энэ нь төгрөгт хөрвөхгүй бол төгрөгийн валюттай харьцах ханшид нөлөөлөхгүй. Хөрвөх тохиолдолд нөлөөлнө. Одоо бидэнд нийт дүн мэдэгдэж байгаа ч ямар хуваарьтай орж ирээд ямар зориулалтаар ашиглагдах вэ, хэдэн хувь нь импортыг санхүүжүүлээд төгрөгийн ханшид шууд нөлөөлөхгүйгээр гадагшлах юм бэ, хэдэн хувь нь дотоодын эдийн засагт төгрөг болж, дотоод зардлаа санхүүжүүлэх юм бэ гэх мэдээлэл байхгүй. Төгрөгт хөрвөж байгаа хэсэг нь л үндэсний мөнгөн тэмдэгийн ам.доллар, бусад валютын эсрэг чангаруулах нөлөөтэй.

**-Хас банк энэ ондоо багтаагаад 300 сая ам.долларын бондыг Сингапурын хөрөнгийн бирж дээр гаргах гэж байгаа. Энэ нь, төгрөгийн ханшид нөлөөлөх болов уу?**

-Яг тэгж ойлгох нь буруу л даа. Хас болон бусад арилжааны банк гадаадаас эх үүсвэр босгоно. Тэртэй тэргүй банкууд томрох ёстой. Дотоодод боломж бололцоо хязгаарлагдмал тохиолдолд гадаадаас мөнгө босгож оруулж ирдэг. Мөн уул уурхайн томоохон компанийн ч гадаадаас мөнгө босгохоор төлөвлөж байна. Орж ирсэн мөнгөний импорт ам.доллар хэлбэрээр гадагшилж байгаа хэсэг нь төгрөгийн ханшид нөлөөлөхгүй. Төгрөгт хөрвөхгүй учраас. Харин дотоод зардлаа санхүүжүүлэх зорилгоор Монгол Улсын нутаг дэвсгэрт бараа ажил үйлчилгээ авах тохиолдолд төгрөгийн эрэлтийг бий болгож ханш чангаруулахад нөлөөлж болох юм.

**-Эрдэнэс Таван толгой ч гадаадаас хөрөнгө босгоно гэж байгаа.**

-Эрдэнэс Таван толгойн IPO хийгдэх эсэх дээр албан ёсны мэдээлэл алга. Хийгдэх тохиолдолд орж ирээд ямар зориулалтаар ашиглагдах вэ гэдгээс хамаарна. Орж ирээд хөрвөхгүй бол ханшид нөлөөлөхгүй.

**-Монголбанк гадаадын банкуудыг Монголд орж ирэхэд дэмжиж ажиллана гэж байсан. Одоогийн байдлаар манай улсад үйл ажиллагаа явуулах санал ирүүлсэн гадаадын банк байна уу?**

-Тийм санал ирж байгаа. Орж ирээд банкны системийн хүрээнд үйл ажиллагаа явуулах нь дараагийн шатны асуудал.Төв банк энэ асуудалд тодорхой зарчим баримталж байгаа. Монголд орж ирээд төлөөлөгчийн газраа нээгээд, цаашид банкны үйл ажиллагаа эрхлэх нөхцөл бололцоог судалж байгаа банкууд бий.

### **Монгол улсын нийт валютын нөөц 2.6 тэрбум ам.доллар**

**-Монгол банк инфляцыг байгаа төвшинд нь барьж чадах уу. Өөрөөр хэлбэл нэг оронтой тоонд?**

-Төв банкнаас инфляцыг хоёр оронтой тоо болгож батлуулах нь утга агуулгын хувьд нийцэхгүй. Инфляц нам тогтвортой байх ёстойг, нөлөөлдөг хүчин зүйлүүдийг хүн бүр мэдэж байгаа. Мөнгөний нийлүүлэлтээс гадна нефть, мах, улс төр гээд олон хүчин зүйл нөлөөлдөг. Төв банкны ганц үүрэг бол үнийг тогтвортой байлгах. Үндсэн зорилт нь үнийн тогтвортой байдал. Энэ зорилтдоо хүрэхийн тулд төв банкнаас шаардлагатай бүх арга хэмжээг авна гэдгээ албан ёсоор хэлж байна.

**-Ирэх онд мөнгөний ханшийн хувьд ямар бодлого баримтлах вэ?**

-Энэ талаар баримтлах зарчмаа 2011 онтой харьцуулах юм бол тодорхой өөрчлөлт байхгүй. Эдийн засгийн багтаамж, шингээх чадвар, орж, гарч байгаа валютын бүтэц, гадаад худалдааны нөхцөл, урсгал тэнцэл ямар байна гэдэг нь өөрөө эдийн засгийн суурь нөхцөл. Тэгэхээр энэ бүх макро тогтвортой байдал макро эдийн засгийн суурь үзүүлэлтүүдтэйгээ уялдаад төгрөгийн ханш валютын эсрэг уян хатан тогтоно. Хэрэв өнөөгийнх шиг богино хугацааны эрэлт нийлүүлэлтийн тэнцвэргүй байдал үүсээд зайлшгүй шаардлагатай гэж үзвэл төв банкнаас зохицуулалт хийнэ. Интервенц хийж оролцохдоо зөвхөн огцом хэлбэлзлийг зөөлрүүлэх чиглэлтэй л оролцоно.

**-Эрэлтээс шалтгаалаад богино хугацаанд ам.долларын ханш өсч байна?**

-Төв банк хэзээ ч таамаглал хийдэггүй. Зах зээлд оролцогчид өөрсдөө таамаглалаа хийх ёстой. Зөв таамаглал хийж, эрсдэлээ зөв удирдахад нь төв банк тогтвортой байдлаар хангах, үнэн бодит мэдээллээр өгөх үүрэгтэй оролцдог. Богино хугацааны эрэлт давамгайлсан шинжтэй нөхцөлд төв банк зүгээр суухгүй. Тодорхой хэмжээний эрэлтийг нь хангаад нөлөөллийг нь ханш дээрээ гаргаж өгнө. Ханш сулрахад зарим хэсэг нь эрсдэлд ордог байхад зарим хэсэгт эерэг нөлөө үзүүлдэг. Тэгэхээр эрсдэлийг зах зээлд оролцогчид өөрсдөө удирдах ёстой. Харьцангуй огцом системийн хэмжээнд эрсдэл учруулахгүй байх асуудлыг төв банк хариуцаж бодлогоо хэрэгжүүлнэ.

**-Монголбанк долоо хоногт хэдий хэмжээний ам.долларын интервенц хийж байна вэ?**

-Интервенцийн арга механизм нь дуудлага худалдаа байдаг. Банкуудад харилцагчид нь өөрсдийнхөө эрэлт хэрэгцээ шаардлагаа хэлнэ. Банкууд нь гадаад валютын орох гарах урсгалын төсөөлөл дээрээ үндэслээд шаардлагатай гэж үзвэл Монголбанкинд худалдах, худалдан авах болон ханшийнхаа саналыг ирүүлдэг. Дуудлага худалдааны хувьд Монголбанк шаардлагатай гэж үзвэл оролцож, оролцсон тохиолдол бүртээ олон нийтэд ямар ханшаар таслав гэдгээ зарладаг. Зах зээлийн хүлээлтэд сөргөөр нөлөөлөх учраас интервенцийн хэмжээг хэлэхээ больсон.

**-Өнөөдөр гадаад валютын нөөц хэр байна вэ. Манай улсын валютын нөөц гадаадын А зэрэглэлтэй банкуудад байршдаг гэсэн яриа байдаг. Хэдэн А зэрэглэлтэй банкид хэр хэмжээний нөөц байгаа вэ?**

-Жил бүр Монголбанк валютын албан нөөц дээр эрсдэлийг хамгийн бага, аюулгүй байлгах стратеги баталдаг. Валютын нөөц маш найдвартай, зэрэглэл өндөртэй, эрсдэлгүй олон улсын төв банкуудад байршиж байгаа. 2011 оны аравдугаар сарын эцсийн статистикаар нийт валютын нөөц 2.6 тэрбум ам.доллар. Харин валютын албан нөөцийг тодорхой үе шатны дараа, хугацааны хоцрогдолтой мэдээлж байх нь зөв. Тэр утгаараа 11 сарын статистик мэдээг дэлгэх арай болоогүй. Валютын ханшийн бодлогын зориулалтаар валютын интервенц хийж байгаа тохиолдолд нөөц тодорхой хэмжээгээр буурна.

## **20 дугаар тогтоол хэдэн онд гарсан бэ гэдгийг сана**

**-Ирэх онд мөнгөний нийлүүлэлт өсөхтэй холбоотой 20 дугаар тогтоол шиг зүйл болох нь. Үүнтэй холбоотойгоор төгрөгийн ханш унана гэх хоосон хөөрөгдөл яваад байна. Үүнд ямар хариу өгөх вэ?**

-20 дугаар тогтоол шиг зүйл болохгүй гэдэг дээр бат итгэлтэй байж болно. 20 дугаар тогтоол хэдэн онд гарсан бэ гэдгийг санах хэрэгтэй. Тэр үед макро эдийн засгийн нөхцөл байдал ямар байсан билээ. 2008 оны хямралыг харахад одоогийн нөхцөл байдал шал өөр болчихсон. 20 дугаар тогтоол шиг зүйл болно гээд төгрөгийн хадгаламжаа доллар болгож байгаа хүмүүс харин 2012 онд эрсдэлд орж болзошгүй.

**-Төсвийнхний цалинг дөрөв, аравдугаар сард нэмнэ. Гэтэл багш нар наана нь нэмүүлэх гээд шаардлага тавиад байна. Магадгүй наана нь цалин нэмэгдэх тохиолдолд инфляц дагаад өсөх нь гэж ярих боллоо?**

-Мөнгөний нийлүүлэлтийг нэмнэ гэсэн утгаараа инфляцад тодорхой дарамт үүсгэж болзошгүй. Гэхдээ инфляцад нөлөөлж байгаа бүтцийн хүчин зүйлүүдээ ангилж үзэх ёстой. Нийлүүлэлтийн хүчин зүйл нь давамгайлсан байх юм бол цалин нэмэгдэхээсээ илүү нийлүүлэлтийн шалтгаан нь инфляцад дарамт авчирна.

**-Хот хөдөөгүй бараа материалын үнэ нэмэгдсэн байна. Энэ нь, инфляцтай холбоотой юу?**

-Хүмүүс хүлээлтээ л зөв удирдах хэрэгтэй болов уу. Зүй нь манай улсын зах зээлд үнэ яаж бүрдэж байна вэ гэдгийг аваад үзчихмээр байгаа юм. Сураг сонсч үнэ нэмдэг тогтолцоо яваад байна. Нефть хомсдолтой байна гэж сонсуугаа шатахууны үнийг нэмдэг. Тиймээс үнийн хяналтаа зөв явуулах хэрэгтэй. Ингэснээр хөөрөгдөөд байгаа инфляцыг тодорхой хэмжээгээр дарах бололцоо бий.

**-Тэгвэл үнийн хяналтыг яаж тавих ёстой вэ?**

-Төрөөс хянах ёстой. Хариуцсан яам, агентлаг байгууллага нь шалгах ёстой. Тухайлбал, баяр болох гэж байгаа энэ үед майонезын үнийг нэмээд “Өө Алтанбулагийн гааль дээр ачаалал их байна” гэж тайлбарлах нь гажууд биз дээ.